

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ АСУУДЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ

2019 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хороо Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн Дэмбэрэлдашийн Баярсайхан тус Хорооны даргаар томилогдсонтой холбогдуулан Эдийн засгийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр нөхөн томилуулахаар Түдэвийн Цэрэнбадралыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Т.Цэрэнбадрал нь 1978 онд төрсөн. 2000 онд МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийг гадаад албаны ажилтан, 2002 онд Санхүү, эдийн засгийн дээд сургуулийг эдийн засагч, нягтлан бодогч мэргэжлээр тус тус төгссөн бөгөөд 2010 онд Либерти дээд сургуульд төрийн удирдлагын магистр, 2014 онд Австралийн Үндэсний их сургуульд бизнесийн удирдлагын магистр хамгаалсан байна.

Тэрээр 2001-2004 онд Гадаад харилцааны яамны Төрийн захиргаа, удирдлагын газарт мэргэжилтэн, 2004-2007 онд Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ-нд атташе, 2008-2015 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газарт хянан шалгагч, Хорооны орон тооны бус зөвлөх, 2014-2016 онд Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ-нд сурталчилгаа, олон нийтийн асуудал хариуцсан ажилтан, 2016-2019 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, орлогч дарга, 2019 оны 9 дүгээр сараас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргаар тус тус ажиллаж иржээ.

Т.Цэрэнбадрал нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа болно.

Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнийг нөхөн томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, холбогдох бусад материалыг Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж,

тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНСЫН
ХОРООНЫ ДАРГА



Ж.ГАНБААТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**Санхүүгийн зохицуулах хорооны
гишүүнийг нөхөн томилох тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Түдэвийн Цэрэнбадралыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр нөхөн томилсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

1.Түдэв Цэрэнбадрал

/Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнд нэр дэвшигч/

2. Хэзээ, хаана төрсөн: 1978 онд Дундговь аймагт төрсөн.
3. Нас, хүйс: 41 настай, эрэгтэй
-
- 4.Үндэс угсаа: Халх
5. Ам бүлийн байдал: Эхнэр, 2 хүүхэдтэй.
6. Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн мэргэжил, эрдмийн зэрэг, цол:
- 1986-1996 онд Нийслэлийн 40 дүгээр дунд сургууль
1996-2000 онд МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийг Гадаад албаны ажилтан
2000-2002 онд СЭЗДС-ийг Эдийн засагч, нягтлан бодогч
2009-2010 онд Либерти дээд сургуулийг Төрийн удирдлагын магистр
2013-2014 онд Австралийн үндэсний их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр
- 7.Ажилласан байдал:
- 2001-2004 онд Гадаад хэргийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын мэргэжилтэн
2004-2007 онд Монгол Улсаас Япон Улсад суугаа элчин сайдын яамны Консулын хэлтэст Атташе
2008-2014 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын мэргэжилтэн, хянан шалгагч
2014-2016 онд Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албанд орон тооны бус зөвлөх
2014-2016 онд Монгол Улсаас Япон Улсад суугаа элчин сайдын яаманд Олон нийтийн асуудал хариуцсан ажилтан
2016-2017 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга
2017-2019 онд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын орлогч дарга
2019.09.04-өөс "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
- 8.Гадаад хэл: орос, англи, япон, польш



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.12.10 № 03/10496
танай 2019.12.06-ны № 1/13148 -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр томилогдохоор нэр дэвшсэн Түдэвийн Цэрэнбадралын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн тус газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

Хүндэтгэсэн,

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



З.БААСАННЯМ

0017733

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИАС

Хорооны бүрэлдэхүүн, ажлын алба

11 дүгээр зүйл. Хорооны дарга, гишүүн, түүнийг томилох

11.1. Хороо нь дарга, 6 гишүүнээс бүрдэнэ.

11.2. Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас томилно.

11.3. Хорооны дарга болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооноос нэр дэвшүүлсэн тус бүр 1 гишүүн орон тооны, бусад дөрвөн гишүүн нь орон тооны бус байна.

11.4. Байнгын хорооноос санал болгох нэр дэвшигч хувийн хэвшлийг төлөөлсөн байж болно.

11.5. Хорооны гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

11.5.1. төрийн улс төрийн албан хаагч;

11.5.2. улс төрийн намын удирдах албан тушаалтан;

11.5.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;

11.5.4. санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдэд ажиллаж байгаа

этгээд;

11.5.5. санхүүгийн үйлчилгээ явуулж байгаа хуулийн этгээдийн энгийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч.

11.6. Хорооны дарга, гишүүн нь эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, Монгол Улсын иргэн байна.

11.7. Хорооны гишүүнд нэр дэвшигчийг Улсын Их Хурал томилоогүй бол энэ хуулийн 11.2-т заасан эрх бүхий этгээд ажлын 14 хоногийн дотор өөр хүний нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд оруулна.

11.8. Хорооны дарга, орон тооны гишүүд төрийн тусгай албан хаагч байна.

12 дугаар зүйл. Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа

12.1. Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

**13 дугаар зүйл. Хорооны дарга, гишүүнийг үүрэгт
ажлаас нь чөлөөлөх**

13.1. Улсын Их Хурал дараахь үндэслэлээр Хорооны дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

13.1.1.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

13.1.2.эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

13.1.3.үүрэгт ажлаасаа чөлөөлүүлэхийг хүсэж өөрөө өргөдөл гаргасан;

13.1.4.энэ хуулийн 11.5-д заасан албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан үндэслэлээр Хорооны дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлүүлэх тухай саналыг түүнийг томилоход нэр дэвшүүлсэн этгээд Улсын Их Хуралд оруулна.

15 дугаар зүйл. Хорооны дарга, гишүүнийг нөхөн томилох

15.1.Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол энэ хуулийн 11.2-т заасан эрх бүхий этгээд өөр хүнийг нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд оруулна.

15.2. Энэ хуулийн 15.1-д заасны дагуу томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний томилолтын үлдсэн хугацаатай адил байна.

-----oOo-----